

МӨНГӨНИЙ ТОЙМ

2011 оны 12 дугаар сар

Инфляци


Хэрэглээний үнийн улсын индекс¹ 2011 онд 10.2 хувь, Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс 11.1 хувиар тус тус өслөө. Улаанбаатар хотын сарын инфляци 1.3 хувь, улсын хэмжээнд сарын инфляци 2.0 хувьтай гарлаа. Суурь инфляци² сарын 0.1 хувь, жилийн 10.0 хувь байв.

Улаанбаатар хотын сарын инфляцид зөвхөн хүнсний барааны үнийн өсөлт нөлөөлсөн бөгөөд хонины махны үнэ 7.4 хувь, үхрийн махных 3.3 хувиар тус тус нэмэгдсэн нь сарын инфляцийн дийлэнх буюу 71.6 хувийг эзэлжээ.


Инфляцид хүнсний барааны үнийн өсөлтийн нөлөө өмнөх онуудтай харьцуулахад буурч, харин бусад бүлгүүдийн үнийн өөрчлөлтийн нөлөө нэмэгдсэн байна. Тодруулбал, 2010 оны 12 дугаар сард хүнсний барааны үнийн өсөлт жилийн инфляцийн 62.1 хувийг бүрдүүлж байсан бол 2011 оны 12 дугаар сард 36.5 хувь болжээ.

Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индексийн жилийн өөрчлөлтийг бүлгээр нь авч үзвэл тээврийн бүлгийн бараа, үйлчилгээний үнэ 21.9 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийнх 17.5 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийнх 11.6 хувь, хүнсний барааных 8.9 хувь, боловсролын үйлчилгээнийх 10.2 хувиар тус тус өссөн нь хамгийн өндөр өсөлттэй бүлгүүд байлаа.

Жилийн инфляци



УБ хотын жилийн инфляцийн задаргаа



¹ Үндэсний Статистикийн Хорооны мэдээ.

² Хэлбэлзэл ихтэй, улирлын өөрчлөлттэй барааг хасч тооцов.

	Жин	Сарын инфляци (Улаанбаатар хот)					
		Инфляци, хувиар			Инфляци, задаргаа*		
		10-р сар	11-р сар	12-р сар	10-р сар	11-р сар	12-р сар
Ерөнхий индекс	100.0	-0.4	0.7	1.3	-0.4	0.7	1.3
Хүнсний бараа, ундаа, ус	41.1	-1.9	0.7	3.0	-0.8	0.3	1.3
Мах, махан бүтээгдэхүүн	16.5	-2.8	-0.6	5.3	-0.5	-0.1	0.9
Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг	3.5	5.5	8.5	5.1	0.2	0.3	0.2
Хүнсний ногоо	4.1	-12.3	1.9	2.4	-0.6	0.1	0.1
Хүнснээс бусад бараа	58.9	0.7	0.7	0.0	0.4	0.4	0.0
Хувцас, бөс бараа, гутал	12.4	2.4	2.7	-0.3	0.3	0.3	0.0
Орон сууц, ус, цахилгаан, түлш	13.4	0.1	0.1	0.0	0.0	0.0	0.0
Тээвэр	8.7	0.0	0.2	0.3	0.0	0.0	0.0
Боловсролын үйлчилгээ	4.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0


	Жин	Жилийн инфляци (Улаанбаатар хот)					
		Инфляци, хувиар			Инфляци, задаргаа*		
		10-р сар	11-р сар	12-р сар	10-р сар	11-р сар	12-р сар
Ерөнхий индекс	100.0	12.6	12.3	11.1	12.6	12.3	11.1
Хүнсний бараа, ундаа, ус	41.1	11.8	11.2	8.9	5.2	5.0	4.0
Мах, махан бүтээгдэхүүн	16.5	30.3	29.0	19.9	4.6	4.4	3.4
Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг	3.5	0.6	2.2	5.4	0.0	0.1	0.2
Хүнсний ногоо	4.1	1.8	0.5	1.8	0.1	0.0	0.1
Хүнснээс бусад бараа	58.9	13.2	13.2	12.9	7.4	7.3	7.0
Хувцас, бөс бараа, гутал	12.4	16.2	18.5	17.5	1.9	2.2	2.0
Орон сууц, ус, цахилгаан, түлш	13.4	13.6	11.7	11.6	1.6	1.4	1.3
Тээвэр	8.7	22.1	21.6	21.9	1.9	1.8	1.8
Боловсролын үйлчилгээ	4.1	10.2	10.2	10.2	0.6	0.6	0.6

*Инфляцийн задаргаагаар буюу инфляцид оруулсан нөлөөллөөр нь харуулав. Өөрөөр хэлбэл бүлгүүдийн нийлбэр ерөнхий инфляцитай тэнцүү болно.

Мөнгөний нийлүүлэлт

Мөнгөний нийлүүлэлт³ өмнөх сараас 4.9 хувь, өмнөх оны мөн үеэс 37.0 хувиар өсч 6412.3 тэрбум төгрөгт хүрчээ. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт 2011 оны 7 дугаар сараас хойш буурсаар байна.


Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт



Тайлант сард гадаад валютын харилцахын жилийн өсөлтийн хурд өмнөх сарынхаас 30.5 нэгж хувь, гадаад валютын хадгаламжийнх 29.6 нэгж хувь, төгрөгийн хадгаламжийнх 15.1 нэгж хувь, төгрөгийн харилцахынх 6.0 нэгж хувь, банкнаас гадуурх мөнгөнийх 5.9 нэгж хувиар тус тус буурчээ.

2011 оны 12 дугаар сарын байдлаар M2 мөнгөний жилийн өсөлтийн 52.6 хувийг төгрөгийн хадгаламж, 26.2 хувийг төгрөгийн харилцах, 12.9 хувийг гадаад валютын хадгаламж, 7.5 хувийг банкнаас гадуурх мөнгө, 0.8 хувийг гадаад валютын харилцах тус тус бүрдүүлжээ.

Нийт мөнгөний жилийн өсөлтийн задаргаа



Нийт мөнгөний жилийн өсөлтөд эзлэх хувь



³ M2-мөнгөний нийлүүлэлт нь бараг мөнгө, M1 мөнгөний нийлбэр.


Төгрөгийн харилцахын нийт мөнгөний жилийн өсөлтөд үзүүлэх нөлөө өмнөх сарынхаас 6.8 нэгж хувь, төгрөгийн хадгаламжийнх 4.0 нэгж хувь, банкнаас гадуурх мөнгөнийх 1.1 нэгж хувиар тус тус өсч, харин гадаад валютын хадгаламжийнх 4.4 нэгж хувь, гадаад валютын харилцахынх 7.6 нэгж хувиар тус тус буурчээ.

Хадгаламж


Нийт хадгаламж өмнөх сарынхаас 2.0 хувь, өнгөрсөн оны мөн үеийнхээс 41.1 хувиар өсч 3890.3 тэрбум төгрөгт хүрэв. Тайлант сард төгрөг болон гадаад валютын хадгаламжийн жилийн өсөлт мэдэгдэхүйц буурчээ. Тодруулбал, төгрөгийн хадгаламжийн жилийн өсөлт өмнөх сарынхаас 15.7 нэгж хувь, гадаад валютынх 29.6 нэгж хувиар буурав. Үүнд 2010 оны 12 дугаар сард эдгээр үзүүлэлтүүд өндөр өсөлттэй байсан нь нөлөөлжээ.

Иргэдийн төгрөгийн хадгаламж өнгөрсөн оны мөн үеэс 40.9 хувь буюу 751.3 тэрбум төгрөг, аж ахуйн нэгж, байгууллагуудын төгрөгийн хадгаламж 96.0 хувь буюу 159.6 тэрбум төгрөг, гадаад валютын хадгаламж 29.6 хувь буюу 223.3 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ. Нийт хадгаламжийн 74.9 хувь нь төгрөгийн, 25.1 хувь нь валютын хадгаламж бөгөөд төгрөгийн хадгаламжийн нийт хадгаламжинд эзлэх хувь өмнөх сарынхаас 1.2 нэгж хувь, өнгөрсөн оны мөн үеийнхээс 2.2 нэгж хувиар нэмэгдсэн байна.

Хадгаламжийн жилийн өөрчлөлт




Хадгаламжийн үлдэгдэл




Нөөц мөнгө

Нөөц мөнгө өмнөх сарынхаас 9.4 хувь, өмнөх оны мөн үеэс 75.5 хувиар өсч 1659.8 тэрбум төгрөгт хүрэв. Тайлант сард Төв банкин дахь харилцах, хадгаламж 12.9 хувь буюу 108.7 тэрбум төгрөг, банкуудын касс 2.6 хувь буюу 4.9 тэрбум төгрөг, банкнаас гадуурх мөнгө 6.1 хувь буюу 29.5 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ. Банкуудын Төв банкин дахь харилцах, хадгаламжийн нөөц мөнгөнд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 12.0 нэгж хувиар нэмэгдэж 57.1 хувь болсон бол банкуудын кассын эзлэх хувь 2.1 нэгж хувиар буурч 11.7 хувь, банкнаас гадуурх мөнгөнийх 9.9 нэгж хувиар буурч 31.2 хувь болсон байна.

Гадаад, дотоод цэвэр активын жилийн өөрчлөлт



Гадаад валютын цэвэр албан нөөц



Гадаад, дотоод цэвэр актив

Гадаад цэвэр актив өмнөх сарынхаас 2.8 хувь, өмнөх оны мөн үеэс 12.8 хувиар өсч 3089.8 тэрбум төгрөгт, дотоод цэвэр актив өмнөх сарынхаас 6.9 хувь, өмнөх оны мөн үеэс 71.2 хувиар өсч 3322.4 тэрбум төгрөгт хүрэв. Гадаад цэвэр активын дийлэнх хувийг эзэлдэг гадаад валютын цэвэр албан нөөц 2011 оны 12 дугаар сард өмнөх сараас 0.8 хувь буюу 17.8 сая ам.доллараар буурч, өмнөх оны мөн үеэс 8.7 хувь буюу 182.8 сая ам.доллараар нэмэгдэж 2273.9 сая ам.доллар болсон байна. Дотоод цэвэр активын жилийн өсөлтийн хурд сүүлийн саруудад харьцангуй тогтвортой байгаа бол гадаад цэвэр активын жилийн өсөлт 2011 оны 7 дугаар сараас хойш 57.3 нэгж хувиар буурлаа.

Нийт мөнгөний 48.2 хувь нь гадаад цэвэр активт, 51.8 хувь нь дотоод цэвэр активт байршиж байна.

Зээл

Хадгаламжийн байгууллагуудаас⁴ олгосон зээл өмнөх сарынхаас 3.7 хувь буюу 202.5 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 72.8 хувь буюу 2376.5 тэрбум төгрөгөөр өсч 5641.2 тэрбум төгрөгт хүрчээ. Хадгаламжийн байгууллагуудаас хувийн хэвшилд олгосон нийт зээл өмнөх сарынхаас 4.5 хувь буюу 134.7 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 67.1 хувь буюу 1253.2 тэрбум төгрөгөөр өсч 3122.0 тэрбум төгрөгт, иргэдэд олгосон зээл өмнөх сарынхаас 2.1 хувь буюу 50.7 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 79.1 хувь буюу 1083.5 тэрбум төгрөгөөр өсч 2452.7 тэрбум төгрөгт тус тус хүрсэн байна. Хувийн хэвшилд олгосон зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт өнгөрсөн оны мөн үеэс 58.5 нэгж хувь, иргэдийнх 27.8 нэгж хувиар өсчээ. Нийт зээлийг өмчлөгчөөр нь авч үзвэл 55.3 хувь нь хувийн хэвшил, 43.5 хувь нь иргэд, 1.1 хувь нь улсын байгууллага, 0.1 хувь нь бусад байгууллагад олгосон зээл байна.


⁴ Хадгаламжийн байгууллагад банкуудаас гадна мөнгөний нийлүүлэлтийн тооцоонд ордог харилцах, хадгаламж хэлбэрээр бусдаас хөрөнгө татан төвлөрүүлдэг санхүүгийн байгууллага (Хадгаламж, зээлийн хоршоо) хамрагдана.

Нийт зээлийн үлдэгдлийн 92.8 хувийг хэвийн зээл, 1.3 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 5.9 хувийг чанаргүй зээл тус тус эзлэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь өнгөрсөн оны мөн үеийнхээс 5.6 нэгж хувиар буурчээ.

Нийт зээл




Чанаргүй зээл



Хүү

Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү 2011 оны 12 дугаар сард өнгөрсөн оны мөн үеэс 3.3 нэгж хувиар өсч жилийн 14.25 хувь болов. Банкуудын төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү⁵ өмнөх сараас 0.6 нэгж хувь, өнгөрсөн оны мөн үеэс 2.4 нэгж хувиар буурч жилийн 15.5 хувь болсон бол гадаад валютынх өмнөх сараас 0.1 нэгж хувь, өнгөрсөн оны мөн үеэс 0.5 нэгж хувиар буурч жилийн 12.1 хувь болжээ. Төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 0.2 нэгж хувиар буурч жилийн 10.5 хувь болсон бол гадаад валютын хадгаламжийн жигнэсэн дундаж хүү өнгөрсөн оны мөн үеэс 0.5 нэгж хувиар нэмэгдэж жилийн 4.5 хувь болсон байна. Төгрөг болон валютын харилцахын жигнэсэн дундаж хүү өнгөрсөн оны мөн үеэс 0.4 нэгж хувиар тус тус буурчээ.



Мөнгөний зах

2011 оны 12 дугаар сард банк хоорондын захын арилжаагаар нийт 498.5 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгджээ. Эдгээр арилжааны жигнэсэн дундаж хүү жилийн 12.11 хувь байна. 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс 2011 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хугацаанд банкууд дунджаар төгрөгийн заавал байлгах нөөцөд 487.9 тэрбум төгрөг, валютын заавал байлгах нөөцөд 219.3 тэрбум төгрөг байлгах

⁵ Зарласан хүү.

шаардлагыг хангаж ажиллав. Банкууд төгрөгийн заавал байлгах нөөцөд 512.7 тэрбум төгрөг, валютын нөөцөд 316.4 тэрбум төгрөг тус тус төвлөрүүлсэн байна.

Валютын ханш

Төгрөгийн ам. доллартай харьцах ханш 2011 оны 12 дугаар сарын эцэст 1396.37 төгрөг болж, өмнөх сараас 55 төгрөг, өмнөх оны мөн үеэс 140 төгрөгөөр суларсан байна. Тайлант сард төгрөгийн ам. доллартай харьцах дундаж ханш 1374.20 төгрөг байв.